

Бурхан бол Гэрэл

Магтаал—Бурхан бол Гэрэл: Бидний сүнсний гэрэлтүүлэг, үнэн бүхний эхлэл болсон Нэгэн

Эшлэл(үүд): 2 Самуэл 22:29; 1 Иохан 1:5; Иохан 8:12

Гэмшил—

Бид Бурхантай нөхөрлөдөг гэж яриад, харанхуйд бид алхваас бид худал хэлдэг, үнэнийг үйлддэггүй ажээ. Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид биентэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг гэм нүглээс цэвэрлэдэг ажээ.

1 Иохан 1:6–7

Талархал—

Учир нь “Харанхуйгаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол Христийн царайн дахь Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн юм.

2 Коринт 4:6

Зуучлан Залбирах—

Хүүхдийнхээ төлөө: Таны Үг _____ ны/ийн, хөл дэхь дэнлүү, зам дахь гэрэл нь байг.

_____ ны/ийн гэрэл бусдын өмнө гэрэлтэж, түүний сайн үйлсийг тэд харснаар тэнгэр дэхь Эцэгийг алдаршуулах болтугай.

Дуулал 119:105, Матай 5:16

Аврагдаагүй нэгний төлөө: Та _____ нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу,

Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэр Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно.

Үйлс 26:18

Оюутнууд: Урьд нь харанхуй байсан та нар өдгөө Эзэн дотор гэрэл тул гэрлийн хүүхдүүд ёсоор яв.

Эфэс 5:8

Багш/Ажилчид:

Учир нь “Харанхуйгаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол Христийн царайн дахь Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн юм.

2 Коринт 4:6

Сургуулиуд: Харин эдүгээ энэ нь бидний Аврагч Христ Есүсийн үзэгдсэнээр илчлэгджээ.

Үхлийг Тэр хүчингүй болгож, амь ба мөхөшгүй байдлыг сайнмэдээгээр гэрэлд авчирсан.

2 Тимот 1:10

ЭХЗ:

Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний хүчирхэг үйлдлийг та нар тунхаглах юм.

1 Петр 2:9



ЭЭЖҮҮД ХАМТДАА ЗАЛБИРАХ НЬ
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

momsinprayer.org